

Тусгай шалгаруулалттай ахлах сургууль болон сонгоны ангиудын гарын авлага

Тусгай шалгаруулалттай ахлах сургууль болон сонгоны анги нь **оюуны өндөр потенциалтай болон авьяаслаг сурагчдыг** нэгтгэсэн тусгай сургуулийн орчин юм.

Өөртэйгөө ижил түвшний хүүхдүүдтэй хамт суралцах нь сурагчдын хичээлийн амжилт болон ерөнхий байдалд эерэг нөлөө үзүүлдэг.

Сурагчид NSW мужийн сургалтын хөтөлбөрийн дагуу хичээллэх хэдий ч багш нар оюуны өндөр потенциалтай, авьяаслаг сурагчдад зориулсан, тусгай заах аргын дагуу хичээл заах болно.

Тусгай шалгаруулалттай ахлах сургуулиуд

Тусгай шалгаруулалттай 4 төрлийн ахлах сургууль бий. Үүнд:

- **бүрэн шалгарсан ахлах сургууль** – бүх сурагчид түвшин тогтоох шалгалтын үндсэн дээр сонгогдоно.
- **хагас шалгарсан ахлах сургууль** – сонгогдсон сурагчид болон тухайн дүүргийн сурагчдыг хослуулсан сургуулийг хэлнэ.
- **хөдөө аж ахуйн шалгарсан ахлах сургууль** - хөдөө аж ахуйн чиглэлээр гүнзгийрүүлсэн сургалттай бөгөөд бүх сурагчдыг академик чадвараар нь сонгодог сургууль юм. Зарим сургуулиудад байрлан суралцах боломжтой сургуулийн дотуур байр байдаг.
- **Aurora College** – эдгээр нь цахим сонгоны ангиуд юм. Хөдөө орон нутаг, алслагдсан бүс нутгийн улсын ахлах сургуулиудын сурагчид хамрагдах боломжтой.

Сонгоны ангиуд

Сонгоны анги нь 5, 6-р ангийн оюуны өндөр чадвартай, авьяаслаг сурагчдад зориулагдсан анги юм. NSW мужийн хэд хэдэн улсын бага сургуулиудад энэхүү анги байдаг.

Aurora College нь орон нутгийн бага сургуулиудад цахимаар сонгоны хичээл ордог ба энэ нь хөдөө орон нутгийн болон алслагдсан бүс нутгийн сурагчдад зориулсан анги юм.

Хаана байрладаг вэ?

Тусгай шалгаруулалттай ахлах сургууль болон сонгоны ангиуд нь NSW мужийн хот суурин, бүс нутаг, хөдөө орон нутагт байрладаг. Та өөрт ойрхон сургуулийг доорх газрын зургаас харна уу.

- [Сонгоны анги олох](#)
- [Тусгай шалгаруулалттай ахлах сургуулийг олох](#)

Хүүхдэд маань тохирох эсэхийг яаж мэдэх вэ?

Таны хүүхэд:

- суралцах дуртай
- маш их сониуч зантай
- ой тогтоолт сайтай
- нарийн, хэцүү асуулт асуудаг
- шинэ зүйл сурахдаа хурдан
- бүтээлч сэтгэлгээтэй
- сонирхсон эсвэл дуртай зүйлдээ гүнзгий төвлөрдөг үү?

Хэрэв эдгээр асуултын зарим нь таны хүүхдэд тохирч байвал тусгай шалгаруулалттай сургууль эсвэл сонгоны анги тохиромжтой байж магадгүй.

Хэрхэн өргөдөл гаргах вэ?

Эцэг эхчүүд өргөдөл гаргах хугацаанд дараах хаягаар цахим бүртгэл хийлгэнэ: shsoc.education.nsw.gov.au

2026 оны тусгай шалгаруулалттай ахлах сургууль болон сонгоны ангид элсэх

2026 оны элсэлтийн өргөдлийн хугацаа **2024 оны 11-р сарын 7-** ноос **2025 оны 2-р сарын 21** хүртэл байна.

Өргөдөл гаргахад хүүхэд маань хэддүгээр ангид байх вэ?

Сонгоны ангиуд

Эцэг эхчүүд хүүхдээ 2024 онд 3-р анги төгсөх үед эсвэл 2025 онд 4-р ангийн эхэн үеэр өргөдөл гаргана.

Тусгай шалгаруулалттай ахлах сургуулиуд

Эцэг эхчүүд хүүхдээ 2024 онд 5-р анги төгсөх үед эсвэл 2025 онд 6-р ангийн эхэн үеэр өргөдөл гаргана.

[Өргөдөл гаргах явц](#) болон оршин суух эрхийн шаардлагын талаар манай вэбсайтаас [хэн сонгоны ангид элсэж болох вэ, хэн тусгай шалгаруулалттай ахлах сургуульд элсэж болох вэ](#) гэсэн хэсгээс дэлгэрэнгүй мэдээлэл аваарай.

Түвшин тогтоох шалгалт

Өргөдөл гаргасны дараа таны хүүхэд шалгалт өгөх ёстой. Сурагчдыг шалгалтын гүйцэтгэл дээр үндэслэн сонгон шалгаруулна.

Шалгалт хэзээ вэ?

Шалгалт **2025 оны 5-р сарын 2-ны Баасан** гарагаас **5-р сарын 4-ний Ням гараг** хүртэл 3 хоногийн хугацаанд явагдана.

Сурагчид зөвхөн нэг өдөр шалгалт өгөх бөгөөд түвшин тогтоох шалгалтанд өөрийн компьютерийг авчрах **шаардлагагүй**.

Шалгалт ямар асуултуудаас бүрдэх вэ?

Уг шалгалт нь сурагчдын уншсан зүйлээ хэр сайн ойлгодог эсэхийг, түүнчлэн математик үндэслэл болон, сэтгэн бодох чадвараа ашиглан хэр сайн дүгнэлт хийдгийг үнэлэх болно. Тусгай шалгаруулалттай ахлах сургуульд өргөдөл гаргагчдаас бичгийн ур чадварын шалгалт мөн авдаг.

Дэлгэрэнгүй мэдээллийг: [Түвшин тогтоох шалгалт](#) гэснээс авна уу.

Би хүүхдийнхээ шалгалтын хариуг хэзээ мэдэх вэ?

Таны хүүхэд шалгалт өгсний дараа, 3-р улиралд танд цахимаар шалгалтын дүн болон дараагийн алхамд юу хийх ёстой талаар имэйл ирэх болно. Хэрэв таны хүүхэд сонгогдсон бол хэрхэн элсэх талаар мэдээлэл авна.

Тэгш Оролцооны Загвар

[Тэгш Оролцооны Загвар](#) нь бүх сурагчдыг тусгай шалгаруулалттай ахлах сургууль, болон сонгоны ангиудад эрх тэгш суралцах боломжийг олгодог.

Энэ загварын дагуу, тусгай шалгаруулалттай ахлах сургууль болон сонгоны анги тус бүрт нийт сурагчдийн 20% хүртэлх хувийг дараах ангиллын оюуны өндөр чадамжтай, онцгой сурагчдыг хамруулна.

- нийгэм-боловсролын боломж багатай бүс нутгаас
- Австралийн уугуул Абориген ба/эсвэл Торрес Страйт арлын угсаатай
- хөдөө орон нутгийн болон алслагдсан бүс нутгийн
- хөгжлийн бэрхшээлтэй.

Эдгээр орон тоог түвшин тогтоох шалгалтанд үзүүлсэн амжилтад тулгуурлан сурагчдад санал болгодог.

Тэгш Оролцооны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг [Тэгш Оролцоо](#)-с авна уу.

NSW мужийн улсын бүх сургуулиудын авьяаслаг сурагчдыг дэмжих нь

Тусгай шалгаруулалттай ахлах сургууль болон сонгоны ангиуд нь NSW мужийн Боловсролын Газраас зохион байгуулдаг өндөр потенциалтай, авьяаслаг сурагчдыг дэмжих олон арга хэмжээнүүдийн нэг юм.

NSW-ийн бүх улсын сургуулиуд өндөр потенциалтай, авьяаслаг хүүхдүүдийг өөрсдийн чадавхийг бүрэн дүүрэн ашиглахад нь дэмжлэг, туслалцаа үзүүлдэг. Манай хэлтсийн [Өндөр Потенциалт, Авьяаслаг Боловсролын Бодлого](#) -ын талаарх илүү ихийг мэдэж аваарай.

Илүү их мэдээлэл хэрэгтэй байна уу?

Дэлгэрэнгүй мэдээллийг дараах вэб хуудаснаас үзнэ үү.

Эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан вэб хуудас

- **Тусгай шалгаруулалттай ахлах сургуулиуд болон сонгоны ангиуд:** education.nsw.gov.au/shs-oc
- **Тусгай шалгаруулалттай ахлах сургуулиуд:** education.nsw.gov.au/shs-yr7
- **Сонгоны ангиуд:** education.nsw.gov.au/oc

Сурагчдад зориулсан вэб хуудас

- **Сурагчдад зориулсан тусгай шалгаруулалттай ахлах сургууль болон сонгоны ангиудын мэдээлэл:** edu.nsw.link/shs-oc-students
- **Сонгоны ангид бүртгүүлэх:** Сурагчдын мэдээллийн төв: edu.nsw.link/OChub
- **Тусгай шалгаруулалттай ахлах сургуульд өргөдөл гаргах:** Сурагчдын мэдээллийн төв: edu.nsw.link/SHShub

Нийгмийн сүлжээ

Манай албан ёсны хэлтсийн фэйсбүүк группүүдэд нэгдээрэй:

- **Ахлах сургуулийн сонгон шалгаруулалт:** edu.nsw.link/shs-fb
- **Сонгоны ангиуд:** edu.nsw.link/oc-fb

Бидэнтэй холбоо барих

Сонгон Шалгаруулах Боловсролын Хэсэгтэй (Selective Education Unit) дараах хаягаар холбогдоно уу.

Имэйл: ssu@det.nsw.edu.au

Утас: 1300 880 367

Утсан орчуулгын үйлчилгээ: 131 450

Хэрвээ танд асуулт байгаа бөгөөд орчуулагчийн тусламж хэрэгтэй бол утсан орчуулгын үйлчилгээний дугаарт залган дараахыг хэлнэ үү.

- өөрийн ярихыг хүссэн хэл
- таны залгахыг хүссэн утасны дугаар.

Оператор Сонгон Шалгаруулах Боловсролын Хэсгийн (1300 880 367) дугаарт залгаж, таны яриаг орчуулах орчуулагчийн шугамд холбож өгөх болно. Энэхүү үйлчилгээ нь үнэ төлбөргүй.